



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 01/700

Улаанбаатар хот

Багануур дүүргийн 131 дүгээр  
цэцэрлэгийн хөрөнгийг данснаас  
дансанд шилжүүлэн бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан 5,407,900.0 /таван сая дөрвөн зуун долоон мянга есөн зуун/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Багануур дүүргийн 131 дүгээр цэцэрлэг /Т.Сувдмаа/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Багануур дүүргийн 131 дүгээр цэцэрлэг /Т.Сувдмаа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
 газрын даргын 2019 оны 12...дугаар  
 сарын 27...өдрийн 0/900 тоот тушаалын хавсралт



Данснаас дансанд шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багануур дүүргийн 131 дүгээр цэцэрлэг

№	Хөрөнгийн нэр	Бүртгэлийн дугаар	Марк дугаар, үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Дансны нэр	
						Нэгж үнэ	Нийт үнэ	Шилжүүлэх данс	Бүртгэх данс
1	Дрож	20186		ш	19	17,000.00	323,000.00	аж ахуйн болон хангамжийн данснаас	Тавилга, эд хогшлын дансруу
2	Дрож	20501		м	10	52,600.00	526,000.00		
3	Дрож	20475		ш	10	38,000.00	380,000.00		
4	Дрож	20205		ш	32	31,250.00	1,000,000.00		
5	Дрож	20472		ш	10	56,000.00	560,000.00		
6	Дрож	20421		ш	10	62,000.00	620,000.00		
7	Дрож	20404		ш	10	48,000.00	480,000.00		
8	Дрож	20178		ш	12	18,000.00	216,000.00		
9	Дрож	20200		ш	16	30,000.00	480,000.00		
10	Дрож	20407		ш	3.3	40,000.00	132,000.00		
тавилга эд хогшлийн дансын дүн							<b>4,717,000.00</b>		
11	өнгөт зурагт	20070		ш	1	179,500.00	179,500.00	аж ахуйн болон хангамжийн данснаас	машин тоног төхөөрөмжийн дансруу
12	өсгөгч	20566		ш	1	511,400.00	511,400.00		
тоног төхөөрөмжийн дансны дүн							<b>690,900.00</b>		
Нийт эд хөрөнгийн дүн							<b>5,407,900.00</b>		